**ДУНДГОВЬ АЙМАГ**
**ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 08 өдөр          Дугаар А/15          Хажуу шинэ ус

Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "Г" Газрын тухай хуулийн 21.4, 27, 30, 31, 38 дугаар зүйлийн Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тогтохбуян овогтой Бадамдэлгэрийн эзэмшилд байгаа 1064м2 зочид буудлын зориулалттай газрыг Эрдэнэсүрэн овогтой Одбаатарын эзэмшилд шилжүүлсүгэй.

2.Энэ захирамжийг гарсантай холбогдуулан 2016.07.08-ны өдрийн А/53 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцож газрын хэмжээг хэвээр үлдээсүгэй.

3.Иргэн Э. Одбаатарын хүсэлтийн дагуу газрын зориулалтыг өөрчилж үйлчилгээний зориулалтаар олгосугай.

4.Эзэмшил газрын хил заагийг тогтоон газрыг хүлээлгэн өгч, гэрээ байгуулан гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Б.Хорол/-д даалгасугай.

5.Газрыг зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж байхыг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА          Ө. МӨНХ-АМГАЛАН